

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

№	Зүйл	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11-р зүйлд зааснаар:
1	11.1.1	Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл: Эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрлийг тодорхой дурдах
2	11.1.2-3	Хуулийн этгээд бол: Улсын бүртгэлийн гэрчилгээ баталгаажуулсан хуулбар;Хувь хүн бол: Иргэний үнэмлэхний баталгаажуулсан хуулбар
3	11.1.4	Улсын тэмдэгтийн хураамж болон Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний үнэ төлсөн баримт: /хураамжийг хурлын шийдвэрийн дараа тушаана/: Тэмдэгтийн хураамж : 12.500 төгрөг, Эрүүл Мэндийн Яам Данс : Улаанбаатар банк, 2611016809 Хаана : Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний үнэ: 6.000 төгрөг Импортын зөвшөөрлийн гэрчилгээний үнэ: 6.000 төгрөг Данс: Төрийн сан, 900020001 Хаана: Эрүүл Мэндийн Яам
4	11.1.5	Тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос шалтгаалан хуульд заасан бусад баримт бичиг: Стандартчилал хэмжил зүйн Үндэсний төвөөс өөрийн үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой стандартыг авч, хангасан байх УМХГ-ын ЭМХУА-ны улсын байцаагчийн дүгнэлт г/м
5	11.1.6.	Тухайн дүүрэг, хорооны засаг даргын санал
Эрүүл мэндийн тухай хуулийн 12-р зүйлийн 3-т зааснаар:		
6	12.3.1	Үүсгэн байгуулагчдын шийдвэр
7	12.3.2	Байгууллагын дүрэм: Уг хуулийн 19–т заасны дагуу дараах зүйлийг тусгасан байна: Байгууллагын нэр, оршин байгаа газар; Үндсэн зорилго, чиг үүрэг; Удирдах бүрэлдэхүүн, түүний эрх хэмжээ; Санхүүжилтийн эх үүсвэр; Өөрчлөн байгуулах, татан буулгах журам.
8	12.3.3	Эмнэлгийн мэргэжилтний бүрэлдэхүүн /мэргэжлийн диплом, лиценз/
9	12.3.4	Барилга байгууламжийн эрүүл ахуйн шаардлага хангасан дүгнэлт Оношлогоо, эмчилгээний болон холбогдох бусад тоног төхөөрөмжийн баталгаа, түүний аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хэмжил зүйн болон эрүүл ахуйн дүгнэлт, тоног төхөөрөмжийн үйлдвэрийн чанарын сертификат, танилцуулга, бүртгэлийн гэрчилгээ г/м
10	12.3.5	Санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, түүний баталгаа (аудит, Үндэсний татварын алба, банкны дансны мэдээлэл, санхүүгийн тайлан гэх мэт)
Эрүүл мэндийн тухай хуулийн 44-р зүйл-д зааснаар:		
11	44.2.	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, протез импортлоход тухайн бүтээгдэхүүний техникийн болон чанарын баталгаажуулалтын баримт бичиг
12	44.3.	Хуулийн 44.2.-т заасан баримт бичигт тухайн бүтээгдэхүүний материалын бүтэц, чанар, техникийн болон бусад үзүүлэлт, баталгаат хугацаа, засвар, үйлчилгээ хийх болон сэлбэг хэрэгсэл, урвалж бодисоор хангах нөхцөлийг тусгасан байна.
13	13.1.1	Байгууллагын үйл ажиллагааны танилцуулга (товч, тодорхой А4 нэг тал дээр)

Санамж:

- Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянан үзэж, “хүлээж авсан”–аас хойш ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэнэ.
- Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлсэн баримт бичгийг олон хуудастай файл хавтсанд дэс дарааллын дагуу хийж асуудал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэж өгнө.
Мэдээлэл авах, баримт бичиг өгөх газар, хаяг:
 - Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв, Эрүүл мэнд, санхүүгийн удирдлагын албаны мэргэжилтэн Э.Золжаргал, утас 70110891 (а)○ Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн веб хуудас: www.nchd.mn○ Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн бодлого төлөвлөлтийн газар, мэргэжилтэн С.Энхжин, утас: 263892 (а)○ Эрүүл мэндийн яамны веб хуудас: www.moh.mn